



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/83

Чойр

Хөрөнгө зарцуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 1.2, 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Улсын төсөв”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудын захиалагчийн албаны зардлын зарцуулалтыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад заагдсан арга хэмжээг төсөвт өртөгт нь багтаан зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-т зөвшөөрсүгэй.

3.Захиалагчийн албаны зардлын зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Ф.Болорцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ

Аймгийн Засаг даргын 2022 оны 03  
дугаар сарын 16 -ны өдрийн А/83  
дугаар захирамжийн хавсралт

**“УЛСЫН ТӨСӨВ”-ӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
АЖЛУУДЫН ЗАХИАЛАГЧИЙН АЛБАНЫ ЗАРДЛЫН ЗАДАРГАА**

№	Хийгдэх ажил	Төсөв /төг/
1.	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Төмөр замын дэлгүүрээс нэгдсэн эмнэлгийн хойд талын зам хүртэл 1.389 км замын 2 туслах замын хяналтын төсвийг шинэчлэн боловсруулсан ажлын зардал	450,000
2.	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхонд шинээр баригдах 1.6 км замын үлдэгдэл ажлын хяналтын төсвийг шинэчлэн боловсруулсан ажлын зардал	275,000
3.	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг Таксины зогсоолоос улсын чанартай автозам хүртэлх 1.15 км замын үлдэгдэл 483.4м замын хяналтын төсвийг шинэчлэн боловсруулсан ажлын зардал	350,000
4.	Говьсүмбэр аймгийн өмчлөлд олгосон газарт /Тэрэгт/ цахилгаан хангамжийн төсвийг салгуулах ажлын зардал	300,000
5.	Холбоо, бичиг хэрэг /А3 цаас, принтер, каноны хор, архивын материал бүрдүүлэх бичиг хэрэг/ хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой шатахуун, багаж, тоног төхөөрөмж, норм дүрэм, програм худалдан авах, мэргэшүүлэх сургалтад хамрагдах зардал	715,628
<b>Нийт</b>		<b>2,090,628</b>